

БАТЛАВ
ЭРХЛЭГЧ

Л. Монгол

Л.АЛТАНШАГАЙ

2021.08.31

1319100014 № 9056041

**Коронавируст халдварын үед 1-р цэцэрлэгийн сургалт
үйл ажиллагааг зохион байгуулахад
мөрдөх түр журам**

Эрхэм зорилго:

Энэхүү журмын зорилго нь коронавируст халдварын тархалтын түвшинтэй уялдуулан хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг зохион байгуулах, халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангах, цэцэрлэгийн орчинд халдварын сэжигтэй болон батлагдсан тохиолдол бүртгэгдэх үед хариу арга хэмжээ авахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Түр журмын үндсэн зарчим:

Сургалт үйл ажиллагааг танхимаар зохион байгуулахад халдвараас сэргийлэх, дэглэнийг чанд сахих, боловсролын үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, хүний нэр төр алдар хүндийг хамгаалах, багш ажилтан, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч өөр хоорондоо харилцан хүндэтгэлтэй, зэлдэг харилцах болон байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох, мэдээллийн нууцлалыг хадгалах зарчмыг баримтална.

1. Сургалт үйл ажиллагааны зохион байгуулалт

- 1.1 Цэцэрлэгийн сургалт үйл ажиллагааг танхимын болон танхимын бус /зайн/ хэлбэрээр тус тус зохион байгуулна. Бүлгийн ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор танхимаар хамрагдаж байгаа хүүхдийн тоо цөөн тохиолдолд бүлгийн багш цахим сургалтыг өөрөө хариуцна.
- 1.2 Цэцэрлэгийн үйл ажиллагааны үргэлжлэх үндсэн хугацаа 8-10 цаг буюу хэвийн, бүтэн цагаар ажиллана
- 1.3 Цэцэрлэгийн бүлгийн өрөөний 1 хүүхдэд ноогдох талбайг 1.5 м²-аар тооцож 20+5 хүүхэд хүлээж авна
- 1.4 Цэцэрлэгт 5 настай хүүхдийг бүрэн, өмнөх хичээлийн жилд цэцэрлэгт хамрагдсан 4 настай хүүхдийг үргэлжлүүлэн хүлээн авах ба 2,3 настай хүүхдийн хөгжлийг дэмжих сургалтыг гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгт тулгуурлан зохион байгуулна.
- 1.5 Сургалтыг зохион байгуулахад хүүхэдтэй ойрын зайнаас харилцах шаардлагатай тохиолдолд багш ажилтан ам, нүүрний хаалт, нэг удаагийн бээлийн заавал хэрэглэх бөгөөд тэдгээрийг тухай бүрт солино.
- 1.6 Сургалт үйл ажиллагааны явцад хүүхдийн онцлог хэрэгцээнээс хамаарч нүүрний хувирал, амны хөдөлгөөнөөр харуулах тохиолдолд багш амны хаалтыг авч, нүүрний хаалт хэрэглэж болно.
- 1.7 Цэцэрлэгийн байранд бөөгнөрөл үүсэхээс сэргийлж хүүхэд хүлээн авах, тарах цагт зохицуулалт хийх

- 1.8 Тухайн нэг бүлгээс халдвартын тохиолдол батлагдсан тохиолдолд тухайн бүлэг зайн сургалтанд шилжинэ.
- 1.9 Ангийн байрлалаас хамаарч тухай давхар, жигүүрийн З хүртл бүлэгт халдвартын тохиолдол батлагдсан нөхцөлд тухайн давхарын бүлгүүд зайн сургалтанд шилжинэ.
- 1.10 З өөр хоорондоо хамааралгүй /нэг жигүүр нэг давхар биш анги болон багш солигддогтүй / З ба түүнээс дээш бүлгийн дотор халдвартын тохиолдол батлагдсан нөхцөлд цэцэрлэгийн бүх бүлгийг зайн сургалтанд шилжүүлнэ.
- 1.11 Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зайн сургалт зохион байгуулах орчин нөхцөлийг бүрдүүлж, багшид дэмжлэг үзүүлнэ.
- 1.12 Онцгой нөхцөл байдалд ажиллах үед багш ажилтны ажлын чиг үүрэг, харилцаа хандлага, ёсзүйн хэм хэмжээ баримтлах дэгийг нарийвчлан тогтоож, цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар баталж мөрдөнө.
- 1.13 Сургалт үйл ажиллагааны явцад хүүхэд, нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэндэд анхаарч, зовуурь шинж тэмдэг илрэх тохиолдолд багш цэцэрлэгийн эмчид яаралтай мэдэгдэнэ.
- 1.14 Хүн ам ихээр цуглардаг талбай, үйлчилгээний газарт аялал зугаалга зохион байгуулахгүй.
- 1.15 Хүүхэд багш ажилтан эцэг эх, асран хамгаалагчийг хамруулсан аливаа уралдаан, тэмцээнийг зохион байгуулахгүй.
- 1.16 Эцэг эх, асран хамгаалагчаар бэлтгүүлэх ариун цэврийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүнийг баталсан журмын дагуу З сараар бэлтгүүлэн авч халдвартгүйжүүлэлт хийж хэрэглэнэ.
- 1.17 Сургалтын хэрэглэгдэхүүнийг хүүхэд дамжуулан хэрэглэхгүй байх дээр анхаарч, хүүхэд бүрт хүртээмжтэй байхаар бэлдэнэ.
- 1.18 Цэцэрлэгийн хөгжим, хөдөлгөөн эрүүл мэндийн танхимын суралтыг тухайн бүлгийн багш зохион байгуулах бөгөөд хөдөлгөөний ачааллыг зохистой түвшинд байлгах, эрүүл мэндийг дэмжихэд чиглүүлэн зохион байгуулна.
- 1.19 Хөгжим биеийн тамирын багш нь сургалт арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэн, зайн сургалтыг зохион байгуулна.
- 1.20 Эрсдэлээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөг гарган, хүн бүр мөрдөж дагана.